



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/240

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр 14.2.3, 14.2.4, 65 дугаар зүйлийн 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.5 дахь заалт, Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2019 оны А/352 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Соёл спортын цогцолборын 500 суудалтай барилгын 3,297,998,199 (Гурван тэрбум хоёр зуун ерэн долоон сая есөн зуун ерэн найман мянга нэг зуун ерэн есөн) төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг аймгийн төсвөөс 2017 онд 135,000,000 төгрөг, 2018 онд 3,162,998,199 төгрөгөөр санхүүжүүлэхээр “Хөвсгөл батчандмань” ХХК-тай байгуулсан ХӨ-2017/4.1.3-А/09 дугаартай гэрээний дагуу 2017 оны санхүүжилтийг аймгийн төсвөөс олгосноос үлдсэн 2018 оны гэрээний төлбөр 3,162,998,199 төгрөгийн санхүүжилтийн 2019 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтын XII.2.1.44 дүгээрт батлагдсан 2,300,000,000(Хоёр тэрбум гурван зуун сая) төгрөгөөр санхүүжүүлэхээр өөрчлөн баталсугай.

2. Жаргалант сумын Соёл спортын цогцолборын 500 суудалтай барилгын ажлыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр байгуулсан гэрээний санхүүжилтийг 2019 онд Улсын төсвөөс санхүүжүүлэхээр өөрчилж, гэрээний хугацааг сунгаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД